

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 20

Хуралдаан 2013 оны зургадугаар сарын 20-ны өдрийн 14 цаг 06 минутад эхэлж, 15 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 31 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ажиллаж байсан ажилтнуудаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ажиллаж байсан Д.Гантөмөр, Т.Мөнгөнцэцэг, Д.Мөнхсолонго, Б.Мөнхханд, Ц.Тэрбиш, Б.Хэрлэнчимэг, О.Мөнхзул, Б.Итгэлбат, Ж.Сүглэгмаа нараас “Төрийн албанаас халах тухай” Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2013 оны 88 дугаар тушаалыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3-ын 6-д заасныг удирдлага болгон: 1. “Төрийн албанаас халах тухай” Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2013 оны 88 дугаар тушаалыг эрх

		<p>зүйн чадамжгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. “Төрийн албанаас халах тухай” 2013 оны 88 дугаар тушаалыг хүчингүй болгож шийдвэрлэхийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнайд даалгах.</p> <p>3. Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу энэхүү тогтоолын 2-т заасныг биелүүлэхийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнайд үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7-д заасны дагуу шүүхэд гомдлоо гаргах эрхтэй болохыг маргааны талуудад мэдэгдэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Цэцэгмаагийн Уртнасанг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэн</p>

		Цэцэгмаагийн Уртнасанг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн халамжийн ерөнхий газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлэх тухай танилцуулах	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргаар ажиллаж байгаа Д.Баярсайханд Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гаргуулах хүсэлт 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 1/1262 тоот албан бичгээр ирүүлснийг судлан үзээд, Д.Баярсайхан нь 2005 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байсан тул Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргаар томилуулах боломжтой гэж дүгнэв.
4	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын, Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Засгийн тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаагийн 2013 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 1/656 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд

		<p>даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сайнбилэгийн ХЭГ/1039 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд тус тус ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 7 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтов.</p>
5	<p>"Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн батлах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13, 35 дугаар зүйлийн 35.1.3, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3 дахь хэсгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар батлах. 2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн 126 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

6	<p>Яам, агентлагийн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 126 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад зааснаар тус тус батлах. 2. Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад зааснаар тус тус томилох. 3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” 2010 оны 74, 2011 оны 88, 2012 оны 42, 57 дугаар тогтоолууд, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2011 оны 102, 2012 оны 67, 111, 117, 118, 125, 126, 128, 129, 130, 138, 137, 145, 148, 150, 151, 156, 149, 152, 155, 164, 2013 оны 05, 78, 79 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
---	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

